



**ОРХОН АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 03 дугаар сарын 24

Дугаар N/09

Жаргалант сум

Ээлжит I хуралдааны тов тогтоох,
хэлэлцэх асуудлыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит I хуралдааныг 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 10.00 цагт хуралдуулахаар тов тогтоосугай.

2.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит I хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3.Хуралдааны бэлтгэл ажлыг ханган зохион байгуулахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Ц.Ганбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Ш.БИЛГҮҮНБААТАР

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын
2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн
№09 дугаар Захирамжийн хавсралт

СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ I ХУРАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэлэлцэх асуудал	Хуралдаанд асуудал танилцуулах албан тушаалтан (Хороо)
1	Төсөл сонгон шалгаруулах хороо, хяналтын зөвлөл байгуулах тухай, хоршоог хөгжүүлэх сангийн 2025 оны зээлийн тов тогтоох тухай	Сумын ЗДТГ-ын жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо хариуцсан мэргэжилтэн Ц.Энхзаяа
2	Иргэдийн гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий орон сууцны журам батлах тухай	Сумын Засаг даргын орлогч Т.Лхагвацэрэн